

XIV-XVI ЗУУНЫ ҮЕИЙН МОНГОЛ-МИНГИЙН ХООРОНД БОЛСОН ДАЙН ТУЛААНЫ ТУХАЙ

*Д.Ундрах**

Abstract: Major transformations of the Central Asian military-political relationships starting from historical period of “Northern Yuan Empire” (1368-1388) of the late Mongolian Yuan Empire led Mongolia (from 2nd half of the fourteenth century through second half of seventeenth century) to neighboring with Golden Horde, later from sixteenth century - with Russia in the north, with Ming Empire and Tibet, later - Golden State on south and south-east, Central Asian countries, Eastern Turkistan on the west, all with large nomadic and civilized populations. In this report we have highlighted Mongolia and Ming military and political relations, as well as conflicts and small battles that have never been studied before.

Key words: Central Asian military-political relationships, Mongol Ming relationships, small battles

Монгол-Мингийн харилцаа (1388-1644 он). Юань улсын (Ухаант) Тогоонтөмөр хаанаас хойш Ар Юань улс (1368-1388)-ын төрийн эрхийг барьсан Аюушридар (Билэгт) (1338; 1370-1378), Төгстөмөр (Усхал) (1342; 1378-1388) нарын хаад цэрэг-улс төрийн гадаад бодлогын залгамж чанар, монгол цэргийн байлдан тулалдах чадварыг нэмэгдүүлэхэд онцгойлон анхаарч байсан тул цэрэг, зэвсгийн давуу хүч бүхий Мин улсын эзлэн түрэмгийлэх үйл ажиллагаа аажмаар тасалдахад хүрчээ. Энэ нь угтаа Тогоонтөмөр хааны цэрэг, дайны дэвшилтэт бодлого, үйл ажиллагаа нь хожмын Монгол хаад, цэргийн зүтгэлтнүүдийн Мин улсын эсрэг амжилттай сөрөн тэмцэх үндэс суурийг бүрдүүлсэнтэй холбоотой байв.

Өгүүлэн буй үеийн харилцааны төлөвийн тухай доктор Н.Ариунгуа “Монголын язгууртнууд төрөлх нутагтаа буцаж ирснээр Монгол-Хятадын харилцаанд үндсэн өөрчлөлт гарч улмаар тэрхүү харилцаа нь бие даасан хоёр орны харилцааны үндсэн дээр үргэлжлэн хөгжих болжээ. Чингэхдээ энэхүү гадаад улс төрийн харилцаа нь хоёр орны дотоод улс төрийн явцаар тодорхойлогдон, зарим нөхцөлд түүнд мөн шууд нөлөөлсөөр иржээ”¹ хэмээн дүгнэсэн байна.

“Ар Юань улс”-ын үе буюу 1368-1388 он хүртэлх хориод жилийн туршид гэхэд тус хоёр улсын хооронд үргэлжилсэн их, бага хэмжээний удаа дараагийн дайн,

* МУИС-ийн ШУС, ХУС-ын Ази судлалын тэнхимийн дэд профессор, түүхийн ухааны доктор (Ph.D)

¹ Ариунгуа Н. ХИҮ-ХҮИ зууны Монгол, Хятадын харилцаа. УБ., 1996. т. 46-48

байлдааны дотроос 1372 оны дайн нь монголын хаад, цэргийн зүтгэлтнүүдийн хувьд Мин улсын цэрэг, зэвсгийн давуу хүчийг эрс шийдвэртэй сөрөн тэмцэх, нэн ялангуяа төр улсынхаа тусгаар тогтнолыг хамгаалан сахихад шийдвэрлэх ач холбогдол бүхий анхны томоохон тэмцэл байснаараа ихэд онцлогтой ажээ. Уг дайны гол зорилго, чиглэлийн талаар гадаад, дотоодын түүхч, судлаачид янз бүрээр авч үзсэний дотор Оросын эрдэмтэн Н.П. Свистунова “Мин улс төр улсынхаа тусгаар тогтнолыг батлан хамгаалахын тулд монголчуудыг бүрмөсөн бутцохиж, умард хил хязгаараа бататгах шаардлагатай байв. Чухамхүү энэхүү зорилгыг хэрэгжүүлэхийн тулд Мин улсын эхэн үед Монгол руу их хэмжээний аян дайн хийжээ” гэсэн бол доктор Д.Идэр “Мин улсын энэхүү дайны гол зорилго бол Юань улсыг бүрэн мөхөөж, түүний хуучин эзэмшил нутгийг цөм өөрийн эрхшээл ноёрхолд оруулахад оршиж байсан юм” гэж үзжээ. Ингээд Монгол Мингийн хооронд болсон том жижиг тулаануудын тухай дэлгэрэнгүй үзье.

1. Монгол, Мингийн хооронд болсон томоохон тулаанууд

Монголын сурвалжид 1369-1370 дайны талаар дурдсан зүйл үгүй ч хятад сурвалжид энэ талаар бичиж тэмдэглэсэн байдаг. Тухайлбал, 1370 оны тулалдааны тухайд “Мин улсын судар”², “Умыг төвшитгөсөн тэмдэглэл” сурвалжид тодорхой тэмдэглэн үлдээсэн байдаг.

1370-аад оны эхээр Монголын Дай Юань улсын эрх баригчид монгол нутагтаа эргэн ирснээс хойш ойрадууд Монголын их хааны хүч чадал бууран доройтсоныг ашиглан хүч чадлаа нэмэгдүүлэхийг оролдох болов. Ингэснээр Ойрад нь Монголыг бүрдүүлэгч нэгэн томоохон хэсэг болжээ. Тухайн үед Ойрад нь Монголын баруун талд оршиж байсан учир түүх судлалд “Баруун Монгол” хэмээн нэрлэдэг. Харин Мин улсын сурвалжид Зүүн Монголыг “Татар”, Ойрадыг “Вала” хэмээн тэмдэглэдэг байжээ. XV зууны эхээр Ойрадын толгойлогч Махамуд, Тайпин, Батболд нар Мин улсаас “ван” цол хүртжээ. Тэдний дундаас Махамуд (Батула) нь хамгийн хүчирхэг байж Зүүн Монголын хаадтай сөргөлдөн тэмцэлдэх болжээ.

1372 оны өвөл Мин улсын эзэн хаан Жу Юаньжан монголчуудын цэрэг, зэвсгийн хүчин чадал богино хугацааны дотор нэмэгдэн хүчирхэгжиж буй мэдээг хүлээн авсан тул нэн даруй мөхөөн дарах зорилгоор олон сайд түшмэдийг дуудан ирүүлж, умард хил хязгаарын хэрэг явдлын тухай хэлэлцэж Мин улсын эзэн хааны зарлиг гаргаж, зарлиг ёсоор Шюй Да жанжин гурван замын 15 түмэн цэргийг ерөнхийлөн захирч, Монголын эсрэг халдан довтолсон нь байлдах арга бодлогын хувьд хүн, хүчний давуу талаа ашиглан монголын цэргийн хүчийг гурван замын их цэргээр хэсэглэн хуваах, улмаар бүслэн хааж устгах зорилготой байв. Зүүн замын цэргийг Ли Вэньжун удирдаж Инчан хот руу мордсон бол баруун замын цэргийг

² “Мин улсын судар”: “Хун У-гийн гутгаар он [1370]-д, Тайзү их жанжин Шюй Да -д их цэргийг ерөнхийлөн захирч, Ши-ань-аар гарч, Динши-г дайрахыг тушаав. [Тэр үед] Хөх[төмөр] яг Ланьжөү-г бүслэж байсан тул яаран [Динши]-д очив. [Хөхтөмөр Мин улсын цэрэгтэй Чэнь-эрюй-д тулалдаад ихэд ялагдаж, олон цэрэг нь буснихад гагц гэргий, хүүхэд зэрэг хэдэн хүнийг дагуулан умарш эчиж, [шар] мөрөнд хүрвээс урсаж явсан мод олж, түүгээр мөрнийг гатлаад даруй буруулан явсаар Хорин [Хархорум]-д очив. Тэр цагт, шүньди төрөл егүүтгэж, тайзы их ор залгамжлаад төрийн хэргийг дахин [Хөхтөмөрт] тушаажээ.....”

Фэн шөн жанжин удирдаж, Гань сү-гийн орчим газар орныг байлдан эзлэхээр тус тус морджээ. Энэхүү Мин улсын гурван замын их цэргийн дотроос Шюй Да-гийн удирдсан дунд замын цэрэг Монголын нутагт хамгийн түрүүнд цөмрөн орсон юм. 1372 оны тавдугаар сард Шюй Да-гийн удирдсан цэрэг Шаньши-д хүрчээ. Лань Юй-гийн удирдсан цэрэг Ян мэнь боомтоор гарч Туул голын сав газарт хүрч ирсэнд Хөхтөмөрийн хошууч цэрэг тосон байлдаад ялагдсан байна. Ли Вэньжун монгол цэрэгт ялагдан, үлдэгдэл цэргийн хамт ухран зугтах үедээ төөрсний улмаас жанжид цэргүүд нь өлсөж, цангасны улмаас маш олон хүнээ алджээ. Фэн Шөн жанжнаар удирдуулсан баруун замын цэрэг, Ганьсү-д довтлон оржээ. Энэ үед Мингийн зүүн гарын дэд жанжин Фү Еудө-гийн удирдсан цэрэг хамгийн түрүүнд Сао лин шан руу довтлон ороод Фөн Шөн-гийн цэрэгтэй хүч хавсарсан байна. Гэвч дунд болон зүүн замын цэрэг ялагдсан мэдээ сонсоод даруй нийслэлдээ буцжээ”³. Энэ тухай хятад сурвалжид тодорхой дурьдсан байдаг.⁴

1372 оны дайнд ихээхэн хохирол амсч, ялагдал хүлээсэн Мин улс Монголын талаар явуулсан цэрэг-улс төрийн хүч түрэмгийлсэн бодлогодоо арга буюу буулт хийхэд хүрч, урьд өмнө Инчан хотоос олзолсон Тогоонтөмөр хааны хөвгүүн Майдарбалыг хорионоос суллан нутаг буцаах арга хэмжээг авсан бөгөөд тус хоёр улс 1374-1378 он хүртэл үндсэндээ бие биенээ хүлээн зөвшөөрсөн найрсаг хэвийн харилцаанд шилжсэн байна.

Монгол-Мингийн цэрэг, улс төрийн харилцаа нэгэн үеийн туршид хэвийн үргэлжилсэн боловч Мин улсын түрэмгий бодлогын уршгаар дахин хурцдаж, цэрэг, зэвсгийн хүчээр удаа дараа дайтан тулгарах болжээ. Нөгөөтэйгүүр Монголын хаад, цэргийн зүтгэлтэн, жанжин нарын өөр зуурын зөрчил тэмцлээс шалтгаалан, Мин улсын цэргийн хүчин зарим талаар ихээхэн амжилт, ялалтанд хүрч байсныг тэмдэглэвэл зохино. Түүхэн баримтаас үзвэл, “Энэ жил (1366 он) Юань гүрний Хөхтөмөр, Ли Сычи, Жан Лянби нар зө эвдрэн өширхөж, олон удаа хоорондоо байлдаж, төрийн зарлигийг огоороход хойд Хятадын ард олон гаслан зовлонд улам нэрвэгдэв”⁵ гэсэн буй.

1381-1387 онд Монгол, Мин улсын хооронд томоохон дайн байлдаан болоогүй ажээ. Учир нь энэ үед Мин улсын эрх баригчид шинээр байгуулсан улсын доторхоо

³ Идэр Д. Юань улсын их түшмэл Хөхтөмөр. УБ., 2012. т. 106-107

⁴ “Мин улсын судар”: “5-р он [1372]-ы хавар, их жанжин шой Да, зүүн этгээдийн дэд жанжин Ли Вэньжун, Барууныг дайлах жанжин Фөн шөн нарт зарлиг буулгаж, цэрэг авхуулан гурван замаар довтлуулав. Их жанжин шой Да дундад замаас Яньмэнь-ээс гарсан боловч тулалдаан ашиггүй болж, боомтыг сахин суув. Фөн шөнгийн цэрэг баруун тийш гарч Ланьжөү-д хүрээ буув. Баруун этгээдийн дэд жанжин Фү Еудө эхлэн давшиж энд тэндгүй тулалдсаар, Саолин ууланд хүрсэн бөгөөд Фөн Шөн нарын цэрэгтэй нийлж, түүний пинжан Буха -г цаазаар авав. шандүло нарын захирсан түшмэд, иргэд 8300 орчим өрхийг буулган авч, эцэстээ Эзнээ чөлгөгөөс гарч Гуа, Шажөү-д хүрэв. Дахин [Ван Баобао-гийн цэргийг] дараалан ялав. [Ли] Вэньжун зүүн тийш Цавчаал-аас гарч Көүвэнь-д хүрсэнд, Юань улсын жанжин цэргийн хүрээгээ орхин дутаав. Тиймээс хөнгөн морьт цэргийг авч Лүчо гол-оос яаравчлан довтолгож, давшаар Туул гол-д Манз, Харажан нарын цэргийг ялж, Орхон гол хүртэл нэхэв. Цааш нэхсээр Чөнхай-д хүрээд, түүний харьяат нар болон хөвгүүд ач нар, цэрэг эрс, эхнэр хүүхэд 1800 орчим хүнийг олзолж, нийслэл хот руу илгээв. шой Да нарыг даруй эргүүлэн татав.

⁵ Мин улсын судар. Тайзү хааны уг тэмдэглэл (Эртний хятад хэлнээс орчуулж, оршил, тайлбар хийсэн: Д.Ундрах, Ч.Содбилэг) УБ., 2017. т. 32

засах хийгээд дотор газар үлдсэн монголчуудыг төвшитгэхөд их хүч анхаарлаа хандуулж байв.

Гэвч 1488 онд томоохон байлдаан болсон нь Буйр нуурын байлдаан байлаа. Мин улсын их жанжин Лань Юй 150000 шилдэг цэргийн хүчээр Монгол оронд цөмрөн орж, Төгстөмөр хааныг дайлснаар эхэлжээ. Мин улсын цэрэг Дайнин-аас Жүндү [*одоогийн Өвөрмонголын Баарин зүүн хошууны баруун хойт хэсэгт буй*] -г чиглэн орж, мөн оны 4 сарын 12-ны үеэр Буйр нуурын өмнө эрэг хүрч, Төгстөмөр хааны гол хүчийг нуурын зүүн хойно 80 гаруй газрын үзүүрт байхыг тагнан мэджээ. Мин улсын их жанжин Ван Би хошууч цэрэг дагуулан Халх голын эрэгт бүхий Төгстөмөр хааны ордныг гэнэдүүлэн дайрсанд умард Юань-ий тайж түшмэл Мэнзи Ягару сандруу угтан байлдсан боловч дайны дунд алагджээ. Огтхон ч бэлтгэлгүй байсан Төгстөмөр хааны цэрэг ихэд ялагдсаны улмаас эцэг, хөвгүүн, жич үйл туслах яамны хэрэг мэдэгч Нэглэй, чинсан Сармун зэрэг хүмүүс умар тийш Хархорум зүг дутаав. Тэндээс Туул голын орчим хүрэх үед эрхэт сайд Есүдэр гэгч Төгстөмөр хааны эсрэг гэнэдүүлэн довтолж, барин авч хөнөөсөн байна”⁶. Зарим сурвалж бичигт энэ тухай тодорхой тэмдэглэсэн байдаг.⁷

1391 онд Ажашири цэрэг хөдөлгөн Мин улсыг эсэргүүцээд Мин улсын цэрэгт ялагджээ. Монгол-Мин (1368-1644)-гийн харилцааны эхэн үед Мин улс илэрхий давамгайлж байсан нь монголын эсрэг “1372 онд 15 түм, 1387 онд 20 түм, 1388 онд 13 түм, нэн ялангуяа Юун Лө хаан өөрийн биеэр таван удаа буюу “**монголын хүчийг хамгийн ихээр хязгаарлан бууруулах ба салган бутаргах**” зорилгоор 1409 онд 10 түм, 1410 онд 50 түм, 1414 онд 50 түм, 1423 онд 30 түм, 1422-1424 (?) онд тус тус үлэмж тооны цэрэг”⁸-ээр удаа дараа халдан довтолсноос мэдэгдэнэ.

Юун Лө хааны өөрийн биеэр хийсэн дайнаас хойш гарсан хоёр том дайны нэг нь “Түмү-гийн тулалдаан” нэрээр, нөгөөх нь “Цагаагчин нохой жилийн тулалдаан” хэмээн тэмдэглэгдсэн байдаг билээ. Түмү-гийн Тулалдааны талаар Хятадын албан ба албан бус түүхэнд олноор тэмдэглэгдэн үлдсэн байдгаас гадна монгол болон гадаадын олон эрдэмтдийн хийсэн судалгаа байдаг. Дайны үйл явц хийгээд Инзун хааныг хэрхэн барьж олзолсон хийгээд Түмү-гийн тулалдааны явцын тухай хятадын албан бус түүх бичлэгийн нэг болох “Жинтайн онд элчилсэн тэмдэглэл”

⁶ Сэвдэнжав, Хэй Лүн. “Монголын эртний цэрэг, дайны толь. Хөх хот., ӨМАХХ. 2000. т. 210-211

⁷ үзэхүл “...Лань Юй газарт нүх ухаж, хоол хийж идээд, нэг шөнөжин довтолгосоор Буйр нуурт хүрэв. Үүр тэмтрэх үед дайсны хүрэнээс 80 газрын зайд очив. Тэр үед их салхи хөдөлж элс шороогоор шуурсны улмаас, өдөр атлаа харанхуй байсан тул, цэрэг ойртож ирснийг мэдэлгүй, дайснууд бэлтгэж завдсангүй. Ван Би гавшгай (уулга) болж, даруй дайсны ойрхон очоод тэдний цэргийг ихэд цохиж тайвэй Манз тэргүүтэй хэдэн мянган хүнийг цавчин хороов. Төгстөмөр хуантайзы Тяньбаонү, жиоань Нецөлай, чөншян, Ширмэн нарын хэдэн арван морьтны хамт дутаав. Харин түүний дэд хөвгүүн Дибанү хийгээд хатад, гүнж 50 орчим, томоохон ноён 3 мянга, эр, эм 7 түмэн хүн, морь, тэмээ, үхэр, хонь 10 түмийг олзолж, дайсны цуяг, зэр зэвсгийг овоолон шатаав. Бас түүний жанжин Харажангийн цэргийн хүрээг өвдэж, түүний олныг цөмийг нь буулган авав. Тиймээс говийн умар этгээд сая амар төвшин болов...” гэжээ. Гэвч хэрэг дээрээ Төгстөмөр хаанаас хойш Монгол оронд дотоодын зөрчил, тэмцэл улам бүр хурцдах болсон нь “Аюушридары хааны хойно Төгстөмөр хаан. Тэр хаан Есүдэрийн гарт халиад, их самуун болсноо Дай Мин Юунлө-гийн цагт буй ээ”

⁸ Сэвдэнжав, Хэй Лүн. “Монголын эртний цэрэг, дайны толь. Хөх хот., ӨМАХХ. 2000. т. 728-730

хэмээх сурвалжид тов тодорхой дүрслэн өгүүлжээ.⁹ Энэхүү сурвалжийг монгол хэлнээ орчуулсан бөгөөд удахгүй бид судалгааны тайлбар хийж нийтлүүлэх болно.

2. Монгол Мингийн харилцаан дахь хилийн мөргөлдөөн, жижиг тулаанууд

Өмнө дурьдсан томоохон дайн тулаанаас гадна Монгол Мингийн харилцааны түүхэнд хэдэн арван жижиг тулаанууд болж байсан юм. Монголчууд Мин улсын түүхэн туршид Хятад улс руу нэгдсэн нэгдмэл дайнд мордоогүй ба жижиг хэсэг бүлэг нүүдэлчид “цохиж өдчихөөд зугтах” маягаар Мин улсын цэрэгтэй мөргөлдөж байсан байна. Тэр нь нэг үгээр хэлбэл “guerilla” хэмээх партизаны дайнтай төстэй тактиктэй байв. Хятад цэргүүд цөл болон Монгол нутгийн нөхцөл байдалд дасаагүй, байгалийн бэрхшээлийг даван туулах бэлтгэл, хүнс ус байхгүй зэрэг гачигдлаас болоод арга зальтай хөдөлгөөнтэй монгол морин цэргийг мөшгин хөөж тэр болгон чаддаггүй тэгсхийгээд орхихоос өөр аргагүй байдаг байсан байна. Хятад сурвалжид тэмдэглэгдсэнээс үзэхүл

1381 оны хавар, Шипинхөү Му Ин-гийн цэрэг Тогооч, Айзү нарыг Хархориноос олзолж, албатыг нь буцаан илгээжээ. Өвөл нь Өлзийбуха-г бас олзолжээ. Дараа жилийн хавар нь, Шюй Да болон дэд жанжин Тан Хө, Фү Ёудө нар Найрбуха-г дайлж Хөбэй-д хүрч, Хуйшань-ыг довтлон, маш олон хүнийг алж, олзолсон байна.¹⁰ 1391 онд Ажашири цэрэг хөдөлгөн Мин улсыг эсэргүүцээд Мин улсын цэрэгт ялагджээ.

Үүний дараа хэсэг хугацаанд хилийн уулгаан мөргөлдөөн намжмал байсан нь Ар Юань-ий дотоодын асуудалтай холбоотой бөгөөд Буняшир хаан суусны дараа Юунлө хаан бичиг илгээн холбоо тогтоохыг оролдож байжээ. Ингээд 1409

⁹ “Эсэн Жөн тун-гийн 14 дүгээр /1449 /оны долдугаар сарын шинийн наймны өдөр цэрэглэн ирж хэрмийн гаднах хот хоргыг бүслэн авчээ. Энэ мэдээг дуулсан өдрөө Фүма дүвэй Жинь Юань нарын дөрвөн жанжин арван мянган цэрэг авч өмнөөс нь дайрчээ. Жинь Юань нарыг цэрэглэж байхад ёслол эрхэлсэн тайган Ван Жэнь хааныг өөрийн биеэр цэрэг авч дайлахыг хэдэнтээ ятгахад нь Тайш Ин Гуо гүн Жан Пү, Тайбао Чөн Гуо гүн Жу Юун нарт цэрэг засаглахыг зарлигдав. Ордны олон түшмэл цугаар үдэхийг гуйхад зөвшөөрсөнгүй. Арван долооны өдөр, цэрэг удирдан хөдөлгөв. Чөн ван Ван Жю шөү зүүн хаалганы баруун нүүрэнд олон түшмэдийг бараалуулахыг зарлигдан, ордны тайган Жинь Ин, түшмэдийн яамны эрхин сайд Ван Жы, Шюэшы Гао Юй, Фүма Чяо Жин нар санал нэгдэв. Түүний дотор цэрэг удирдах эрхин сайд Ван Зуо, Куан Е, Шюэшы Цао Най нар болой. Тавин мянган цэргийг удирдан Цавчаал боомтоор гарч Шюаньфү-д хүрч Жин Юань ялагдсан мэдээг сонорджээ. Хааныг Датун-д ирэхэд нь хар үүл дээвэрлэн бөөгнөрч аянгат бороо орсон тул Ван Жэнь жихүүцэн дагжиж цэргээ буцаан эргүүлэв. Наймдугаар сарын арван гуравны өдөр, Чоно ууланд хүрч бүдүүлгийг хөөв. Жу Юун нар гучин мянган морьт цэрэг авч дайтсан боловч бүгд ялагдан үхэж, нэг ч морь харьж ирсэнгүй. Мөн өдөр, цэрэг Түмү-д хүрч, үхэлдэн тулалдсаар Хуай лай хотод хүрэхэд хорин мод газар байв. Хуай лай хотыг хамгаалах хүсэлтэй байлаа. (Ван) Жэнь мянга илүү хөсөг тэргээр хойноос хүрч ирж үлдэн Түмү-д буудаллав. Хажууд булаг шанд үгүй, мөн бүдүүлгүүд дайрсаар байв. Арван дөрөвний өдөр явахыг хүсэвч бүдүүлгүүд бүсэлсэн байсан тул хөдөлж зүрхэлсэнгүй. Цэргүүд гар мухардаж, өлсөж цангав. Арван тавны өдөр бүдүүлгүүд элч илгээж бичиг өргөв.... Цао Най-г зарлигийн эх бэлдэн хоёр хүн сонгож бүдүүлгүүд рүү элчээр явуулан, өргөө ордноо нүүлгэхийг зарлигдав. Буцах үед цэрэг жагсаал хэдийнэ сарнин үймж, энд тэндгүй болох тулааныг зогсоож дийлэхээргүй болов. Бүдүүлгийн морьт цэрэг дайран орж ирж манай цэргийн дунд чанга дуугаар: “Хуягаа тайлж хутгаа хаяагсдыг алж хороохгүй” хэмээн хашгирав. Олон цэрэг нүцэглэн шалдалж гишгүүр дөвсгэр мэт үхэж байлаа. Бэхлэлт шуудуу байв. Бүдүүлгүүд дунд цэрэг рүү орж ноёд баатруудыг дагаж нумын суманд харвагдан бие цогцос нь зараа мэт болжээ. Хаантан өөрийн цэргийн хамтаар мориндоо мордож бүслэлтийг сэтлэх гэсэн ч гарч чадсангүй бүдүүлгүүдэд баригджихуй”

¹⁰ Мин улсын судар-III. Олон шастир (Эртний хятад хэлнээс орчуулж, оршил, тайлбар бичсэн Д.Ундрах, Ц.Цэрэндорж, Ч.Содбилэг) Редактор: Ц.Цэрэндорж. УБ., 2018. т. 129

онд түүний харьяат Өлзийтөмөр нарын 22 хүнийг олзолсон байдаг. Ингээд намар нь дээр томоохон дайн өрнөсөн юм. 1414 онд Юунлө Ойрадтай дайтаж үүнээс хойно 8 жил амар тайван байтал Аругтай 1422 оны хавар Шинхө-д халдахад Юунлө өөрийн биеэр цэрэг хөдөлгөж довтолсон байна. Үүнээс хоёр жилийн дараа Кайпингийн харуулын жанжны Аругтай дахин хил хязгаарыг тонон дээрэмдлээ хэмээн мэдээлснээр Юунлө хаан дахин өөрийн биеэр цэрэглэж Даланнөмрөг гол хэмээх газар хүрсэн байдаг. Юунлө хаан үгүй болсны хойно Шюаньдө хаан ор залгасны арав дахь жил дээр Аругтай хүүгийн хамт Ойрадын Тогоон тайшид алагдснаар Монгол Мингийн харилцаанд шинэ тоглогч нар гарч ирсэн юм. Удгал тайван байсан хил хязгаарын мөргөлдөөн дахин гарах болжээ.

Тогооны хөвгүүн Эсэн тайш 1449 оны намар, Мин улсын хилийг довтлон орсон ч Тогтобухагийн ятгалгаар дээрэм тонуул хийгээгүй байна. Гэвч Эсэн тайш мөн онд өөрийн биеэр цэрэг хөдөлгөж ирсэн Инзун хааны олзолж энэ дайн Түмүгийн тулаан гэж түүхэнд үлдсэн байдаг.¹¹

Түмүгийн тулааны дараа болсон хил орчмын мөргөлдөөнийг хятад сурвалжид: *“1458 онд Болай Шааньши-д ихээр халдан дээрэмдсэнд, Аньюань хөү Лю Фү тэднийг хааж байлдсан боловч ялагдав.”*¹² хэмээн тэмдэглэжээ. Болай 1463 онд дахин хилийг уулгалан Пинлү хот довтолж дохигч Шюй Юун нарыг урхидан отоонд оруулж хороожээ. Үүний дараа Болай нар жил бүр алба барьж, олон удаа уулгалан дээрэмдэх бөгөөд боомтын гадна ирж очин, баруун зүгт Ойрадыг довтолно хэмээгээд, басхүү олон удаа гурван харуулыг довтлон булаан дээрэмдэхийг оролдож байв.¹³ 1465 оны хавар, Болай Урианхайн 90 мянган морьт цэргийг дагуулж Ляохө нэвтэрч, өвөл нь дахин халдан довтолсон байдаг. 1466 оны зун, Яньсүй-г довтолоход хааны зарлигаар 20 000 цэрэг хөдөлж тулалджээ.

1468 оны өвөл Муулихай хэмээгч Яньсүй-д халдан довтолсон байна. Үүний дараа 1469 оны хавар дахин халдан довтолжээ. 1470 оны хилийн довтолгоог Болунай, Оручи, Бэгэрсэн, Болоху Баянмөнх нар нийлж хийсэн бөгөөд Хөтао-г эзлэн авсан байна¹⁴ 1473 оны намар, Мандуул, Болоху нар хамтдаа Вэйжөү -г халдан довтолсон байна. 1474 оноос Даян хаан Батмөнх Хөтао, Янсүй-д халдах болсныг сурвалжид: *“Тэр жил, гурван удаа Ляодунд халдан довтолж, олноор алж, тонон дээрэмдэв. Дараа жил нь, Шюаньфү, Датун, Яньсүй зэрэг олон хязгаар бүгд хэлмэгдэн хохиров.”*¹⁵ хэмээн тэмдэглэжээ.

1477 оны өвөл, Даян хаан дахин Хөтао-д нутаглав. Улмаар 10 түмэн морьт

¹¹ Мин улсын судар-III. Олон шастир (Эртний хятад хэлнээс орчуулж, оршил, тайлбар бичсэн Д.Ундрах, Ц.Цэрэндорж, Ч.Содбилэг) Редактор: Ц.Цэрэндорж. УБ., 2018. т. 144

¹² Мин улсын судар-III. Олон шастир (Эртний хятад хэлнээс орчуулж, оршил, тайлбар бичсэн Д.Ундрах, Ц.Цэрэндорж, Ч.Содбилэг) Редактор: Ц.Цэрэндорж. УБ., 2018. т. 148

¹³ Мин улсын судар-III. Олон шастир (Эртний хятад хэлнээс орчуулж, оршил, тайлбар бичсэн Д.Ундрах, Ц.Цэрэндорж, Ч.Содбилэг) Редактор: Ц.Цэрэндорж. УБ., 2018. т. 150

¹⁴ Мин улсын судар-III. Олон шастир (Эртний хятад хэлнээс орчуулж, оршил, тайлбар бичсэн Д.Ундрах, Ц.Цэрэндорж, Ч.Содбилэг) Редактор: Ц.Цэрэндорж. УБ., 2018. т. 156

¹⁵ Мин улсын судар-III. Олон шастир (Эртний хятад хэлнээс орчуулж, оршил, тайлбар бичсэн Д.Ундрах, Ц.Цэрэндорж, Ч.Содбилэг) Редактор: Ц.Цэрэндорж. УБ., 2018. т. 161

цэргээр Хуамачы, Яньчы-гаас довтлон орж, сарнин тархаж, Гүюань болон Ниншягийн хилийг тонон дээрэмдсэн байна. Даян хаан энэ мэт хилийн довтолгоон олныг хийснийг хятад сурвалжид дурьдахдаа он сарыг тодорхой бичилгүй харин “Шяованзы олонтаа уулгалан дээрэмдэхээр ирж, алж хороон, тонон дээрэмдсэн нь маш харгис хэрцгий бөлгөө. Дахин таван түмэн морьт цэргээр Датун-г довтолж, Шуожөү рүү довтолгон, Ма-и -г тонон дээрэмдэв. Хуанди Шяньнин хөү Чю Юэ-г зунбин-гаар томилж тэднээс хамгаалах зарлиг буулгав. Ваньчюань харуулд тулалдаж, 3 хүнийг алж, 10 дахин ихийг алдсан атлаа, ялсан хэмээн айлтгав. Дараа жилийн нь намар, дайсны үргэлжилсэн цэргийн хүрээ хэдэн арав хүрч, Шюаньфү (宣), Датунгийн боомтод халдаж, тусад нь нэг түмэн морьт цэрэг илгээн Хуайань уулгалан дээрэмдэв.”¹⁶ гэжээ. 1516 оны намар, Даян хаан 7 0000 морьт цэргээр зам хуваан довтлон, зунбин Фань Хао нартай тулалджээ. Дараа жил нь буюу 1517 оны өвөл, Шяованзы 50000 морьт цэргээр Юйлинь-д халдан довтолж, зунбин Ван Шюнь Инжөү –г бүсэлсэн байна. Энэ тулааны тухай “Мин улсын сударт” : “Хуанди Янхө өөд заларч, өөрийн биеэр тус тусын хийх ажлыг нь хуваарилж, олон жанжин дээр очиж туслуулаад, үхэн тулалдсанд, дайсан яваандаа ухран одов. Дараа өдөр нь дахин ирж довтолсонд, луу цагаас тахиа цаг хүртэл, 100 орчим удаа байлдаж, дайсан баруун тийш цэргээ татаж одов. Пинлү, Шуожөү хүртэл нэхэн хөөхүйеэ, их салхи гарч хар манан татаж, гэгээн цагаан өдрөөр харанхуйлсанд, хуанди эргэн ирж, засгийн газарт хандан дайсныг ялсан тухай дэлгэрэнгүй мэдэгдэхийг тушаав. Түүнээс хойш жил бүр хязгаарыг халдах боловч, аюумишггүйгээр ихээр халдаж үл чадах бөлгөө”¹⁷ гэж тэмдэглэжээ.

1532 онд Боди-Алаг хаан Мин улстай харилцахыг гуйж ирэхэд нь Мин улсын хаан зөвшөөрөөгүйгээс болж хэдэн арван мянган цэргээр уулгалан довтолгосон байна. Тэрбээр 1544 оны өвөл, Ваньчюань баруун этгээдийн харуулыг довтолж ороод, Юйжөү болон Вань шянь-д хүрчээ. Үүнээс хойш Боди-Алаг хаан цэргийн хэрэгт дургүй болж орд өргөөгөө зүүн тийш нүүлгэсэн тухай хятад сурвалжид тэмдэглэжээ. 1533 оноос Гүнбилэг мэргэн жонон, Түмэдийн Алтан хан нар Мин улсын хил хязгаарыг довтолох болжээ. Гүнбилэг мэргэн жонон 1533, 1536 онуудад Мин улс руу довтолж байжээ.

Алтан хан 1545 оны намар, Яньсүй, Датун, Богөюй-д халдаж, 1549 оны хавар, Шюаньфү-гийн Дишүйя-д халдав. 1550 оны цагаан нохой жил Алтан хан Мин улсын хилийг довтлон нийслэлд ойртон очсон байдаг. Дараа нь 1552 оны хавар, Датун-д, 1554 оны хавар, Шюаньфү-гийн Чайгөү хоргод, 1556 оны зун, гучин мянган морьт цэргээр Шюаньфү-д, халдаж дараа жил нь хорин түмэн морьт цэргээр Датунгийн хязгаарыг хуваан уулгалан дээрэмдсэн байна.¹⁸ Алтан ханы сацуу түүний дүү Лаобадүгийн халдан довтолгосон талаар “Мин улсын сударт”:

¹⁶ Мин улсын судар-III. Олон шастир (Эргний хятад хэлнээс орчуулж, оршил, тайлбар бичсэн Д.Ундрах, Ц.Цэрэндорж, Ч.Содбилэг) Редактор: Ц.Цэрэндорж. УБ., 2018. т. 165

¹⁷ Мин улсын судар-III. Олон шастир (Эргний хятад хэлнээс орчуулж, оршил, тайлбар бичсэн Д.Ундрах, Ц.Цэрэндорж, Ч.Содбилэг) Редактор: Ц.Цэрэндорж. УБ., 2018. т. 170

¹⁸ Мин улсын судар-III. Олон шастир (Эргний хятад хэлнээс орчуулж, оршил, тайлбар бичсэн Д.Ундрах, Ц.Цэрэндорж, Ч.Содбилэг) Редактор: Ц.Цэрэндорж. УБ., 2018. т. 180, 181

“Алтаны дүү Лаобадү дахин хэдэн түмэн дагуулан Хөлүкөү-д орж ирээд, Юунтин болон Чяньань-д халдсанд, дэд зунбин Жян Чөншюнь хүчлэн тулалдаж амь үрэгдэв. Зун нь, гэнэт Шюаньфү-гийн Мавэйлян-д халдаж, дэсэлсэн захирагч дарга Чи Мян тулалдаанд амь үрэгдэв. Намар нь, дахин Датунгийн баруун этгээдийн харуулын нутагт орж ирсэн бөгөөд, 70 орчим хоргыг нураан эвдэж, алагдсан олзлогдсон хүн маш олон бөлгөө.” гэжээ.

Харин мөн оны өвөл Алтан ханы ахмад хөвгүүн Сэнгэдүүрэн Шюаньфү, Жи бэхлэлтэд халдсан тухай мэдээ бий. 1559 оны хавар, Лаобадү, Сэнгэ нар Мин улсад халдаж, Хуйжөү-д буудалласан байна.¹⁹ 1560 онд Мин улсын хил хязгаар луу олон удаа довтолгосныг хятад сурвалжид тэмдэглэсэн байдаг ч яг хэн удирдаж довтолсныг бичээгүй, зөвхөн *“Тэр жил, Датун, Яньсүй, Жи бэхлэлт, Ляодунгийн хязгаарт халдах нь нэг ч өдөр үл зогсох бөлгөө.”*²⁰ гэжээ.

Түмэн засагт хаан 1562 онд Мин улсын Фүшүнь д халдаж, зунбин Хэйчүнь -д ялагдсан ч өвөл нь, дахин Фөнхуан хотыг довтолж дээрэм тонуул хийжээ. 1563 оны хавар, Сэнгэдүүрэн Шюаньфү-гийн Дишүйя-д халдсан байна.²¹ Мөн 1565 оны хавар, Шюаньфү-гийн Шымалинь-ээс гэнэт давшиж, тархан сарниж дотоод газрыг уулгалан дээрэмджээ. 1567 онд Алтан хан олон удаа Шаньши-д халджээ. Мөн оны намар нь, дахин олон түмэн цэргийг авч гурван зам хуваан Жинпин, Шуожөү, Лаоин, Пяньтөү боомт зэрэг олон газарт халдахад нь Мин улсын хязгаарын жанжин хамгаалж чадахгүй учир зугатаж, Көланы, Фэньжөү-г довтолж, Шыжөү-г эвдээд, Жыжөү -гийн Ван Лянцай-г хороож, түүний ард иргэдийг алж хяджээ.. Дахин Шяо-и, Жешю, Пин-яо, Вэньшүй, Жяочөн, Тай-юй, Шижөү -гийн хоорондох газрыг ихэд уулгалан дээрэмдэж, алж хяджээ.

1568 онд Чайгөү-д халдаж сахигч түшмэдийг нь хороосон байна. 1570 оны намар, Хуан тайж Сэнгэдүүрэн Хэмэрлэг жөү-д халдсан байна. Алтан хан Багана ачийн хэрэг явдлаас болж Мин улстай найрамдлын хийгээд хилийн худалдааны гэрээ хийсэн тул Мин улсад халдахаа зогсоосон юм. Алтан ханыг нас барсны сүүлчээр Чөрүхэ залгаж хатан Саньнянзы буюу Юнхэний хамтаар цэргээ засч Мин улстай олон жилийн турш найртай оршиж байлаа.

Харин Түмэн засагт хаан дөчин мянган морьт цэргээр Жиньчюань хүрээнд 1579 оны өвөл халджээ. Үүнээс хойш Чин Мин улсыг мөхөөх хүртэл Монголын хаадын шууд угсааны ноёд Мин улстай найрамдалт харилцаатай оршиж байв.

Мөн түүнчлэн хил хязгаарын жижиг ноёд, жанжид Мин улстай арилжаа наймаа хийх хүсэлтийг нь хүлээн аваагүй гэдгээр шалтаглан хил хязгаарт халдаж байсан юм. Тухайлбал, 1592 онд Ниншя-гийн жанжин Бобай тэргүүтэн Бошигт,

¹⁹ Мин улсын судар-III. Олон шастир (Эргний хятад хэлнээс орчуулж, оршил, тайлбар бичсэн Д.Ундрах, Ц.Цэрэндорж, Ч.Содбилэг) Редактор: Ц.Цэрэндорж. УБ., 2018. т. 182

²⁰ Мин улсын судар-III. Олон шастир (Эргний хятад хэлнээс орчуулж, оршил, тайлбар бичсэн Д.Ундрах, Ц.Цэрэндорж, Ч.Содбилэг) Редактор: Ц.Цэрэндорж. УБ., 2018. т. 183

²¹ Мин улсын судар-III. Олон шастир (Эргний хятад хэлнээс орчуулж, оршил, тайлбар бичсэн Д.Ундрах, Ц.Цэрэндорж, Ч.Содбилэг) Редактор: Ц.Цэрэндорж. УБ., 2018. т. 183

Жуантулай нар халдаж ирэхэд, зунбин Ли Рүсун довтолж няцаажээ.

1596 оны хавар, бүгд захирагч сайд Ли Ли нь хүчирхэг цэргийг 3 зам хувааж хязгаараас гараад, Бошигтын хүрээг довтолж, нийт 409 хүнийг алж, адуу мал, зэвсэг хэрэгсэл хэдэн мянгыг олзолсон ажээ. Энэ тухай сурвалжид: *“Холочигийн аймгийн олон, дахин Таожөгү-г хялмалзсанд, Ли нь дэсэлсэн захирагч дарга Жөү Гуожу тэргүүтнийг илгээж Манлачуаньнао-д тэднийг довтлоод, 136 хүнийг алав. Намар нь, Зоригт, Ачит, Холочи тэргүүтэн хамтаар үгсэн баруун хязгаарыг довтолжээ. [1603], [Ши]хай (Хөхнуур) аймаг олон удаа Шааньши-гийн хязгаарт халдсан тул, бинбэйфүшы Ли Зышы, зунбин Сү Рүшюнь, Да Юнь тэргүүтэн тэднийг довтолж зугатаалгажээ”* хэмээсэн байна.

1605 оны зун, зүүн аймгийн Зайсай Чинюнь хоргын шөү-юй түшмэл Шюн Лүнь-ийг өдөөн урхидаж, хороосонд, Мин улсын засгаас тархаах зарлиг буулгаж түүнтэй худалдаа хийх, шан хишиг хайрлахыг зогсоосон байна. Үүний сүүлчээр 1607 оны орчимд бололтой хил хязгаарыг халдан довтолсон тухай нэг мэдээнд: *“Удалгүй Чөрүхэ үхсэн боловч, залгамжлах үргүй тул, Шударга эетэй үжсин харьяат аймгийг удирдаж, урьдын адил алба өргөн барих бөлгөө. Баруун аймгийн Индин, Дайчин нар олон удаа аймгийн олноо авч зүүн, баруун хязгаарт халдав. Яньсүй-гийн аймгийн Мөнхишири бас шан хишиг хүртэхэд багтах гэж, үргэлж хил хязгаарыг уулгалан дээрэмдэх бөлгөө.”*²² гэжээ.

ДҮГНЭЛТ

XIV-XVI зууны үеийн Монгол Мингийн харилцаа угтаа бол цэрэг дайны харилцаа зонхилсон байсан бөгөөд эдгээр дайн тулааны гол шалтгаан нь эдийн засаг, худалдаа хийгээд эрх мэдлийн төлөөх тэмцэл байсан юм. Өгүүлэн буй үеийн улс төр, эдийн засгийн харилцааны талаар цөөнгүй судалгаа гарсан хэдий ч цэрэг дайны харилцааны талаарх судалгааны бүтээлүүд арвин бус байдаг. Эрдэмтэд томоохон дайн тулааныг тухайлан судалж дүгнэлт өгсөн байдаг. Энэ дундаас томоохон дайнуудыг онцолдог бол өгүүлэн буй хугацааны туршид Монгол Мингийн хооронд 38 удаагийн бага тулаан, хилийн мөргөлдөөн болсон байгааг бид хятад сурвалжаас олж үзлээ. “Ар Юань” –ий үед болсон дайн тулаанууд монголын хаад, цэргийн зүтгэлтнүүдийн хувьд Мин улсын цэрэг, зэвсгийн давуу хүчийг эрс шийдвэртэй сөрөн тэмцэх, нэн ялангуяа төр улсынхаа тусгаар тогтнолыг хамгаалан сахихад шийдвэрлэх ач холбогдол бүхий анхны томоохон тэмцэл байснаараа ихэд онцлогтой ажээ. Уг дайны гол зорилго, чиглэлийн талаар гадаад, дотоодын түүхч, судлаачид янз бүрээр авч үзсэний дотор Оросын эрдэмтэн Н.П. Свистунова “Мин улс төр улсынхаа тусгаар тогтнолыг батлан хамгаалахын тулд монголчуудыг бүрмөсөн бутцохиж, умард хил хязгаараа бататгах шаардлагатай байв. Чухамхүү энэхүү зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Мин улсын эхэн үед Монгол руу их

²² Мин улсын судар-III. Олон шастир (Эртний хятад хэлнээс орчуулж, оршил, тайлбар бичсэн Д.Ундрах, Ц.Цэрэндорж, Ч.Содбилэг) Редактор: Ц.Цэрэндорж. УБ., 2018. т. 196

хэмжээний аян дайн хийжээ” гэсэн бол доктор Д.Идэр “Мин улсын энэхүү дайны гол зорилго бол Юань улсыг бүрэн мөхөөж, түүний хуучин эзэмшил нутгийг цөм өөрийн эрхшээл ноёрхолд оруулахад оршиж байсан юм” гэж үзсэн байдаг. Харин дараа дараагийн дайн тулаанууд нь монголын хаад ноёд Мин улстай эдийн засгийн харилцаа тогтоох, Мин улсаар хүлээн зөвшөөрүүлэх гэсэн оролдлогын үүднээс үүдэн гарсан дайн тулаанууд байдаг юм. Мөн түүнчлэн 270 гаруй жилийн хугацаанд болсон 38 удаагийн тулааны зөвхөн 7 удаагийнх нь л Мин улсын талаас өдөөсөн дайн тулаан байжээ.

НОМ ЗҮЙ

1. Ариунгуа Н. XIV-XV зууны Монгол, Хятадын харилцаа. УБ., 1996.
2. Гангын урсгал [Монгол бичгээс хөрвүүлж, оршил бичиж, тайлбар хавсралт хийсэн Баяртуяа Б., Батдорж Ц., Пүрэвдэлгэр Б.] Гомбожав. УБ., 2006.
3. Мин улсын судар-I. Уг тэмдэглэл I-XII дэвтэр (Эртний хятад хэлнээс орчуулж, оршил, тайлбар бичсэн Ундрах Д., Цэрэндорж,Ц. Содбилэг Ч.) Редактор: Цэрэндорж. Ц.УБ., 2018.
4. Мин улсын судар-III. Олон шастир (Эртний хятад хэлнээс орчуулж, оршил, тайлбар бичсэн Ундрах Д., Цэрэндорж,Ц. Содбилэг Ч.) Редактор: Цэрэндорж. Ц.УБ., 2018.
5. Монгол улсын түүх (XIV зууны дунд үеэс-XV зууны эхэн үе) Гутгаар боть. УБ., 2003.
6. Монголын эртний цэрэг, дайны толь. Сэвдэнжав, Хэй Лүн. Хөх хот., ӨМАХХ. 2000.
7. Сэвдэнжав, Хэй Лүн. “Монголын эртний цэрэг, дайны толь. Хөх хот., ӨМАХХ. 2000.
8. “Умарш дайлсны хожуу тэмдэглэл” Ундрах Д., Отгонгэрэл хэмээх сурвалжийн тухайд” “Оюуны хэлхээ” 2018
9. Умард Юаний түүх. Дай Хуан Э, Б.Буян Хөх хот., ӨМАХХ. 1991.
10. 薄音湖 王雄《明代蒙古汉籍史料汇编》第一辑 内蒙古大学出版社 呼和浩特 2006
11. 沈起炜 《中国历史大事年表/古代/》上海辞书出版社1983